



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/223

Улаанбаатар хот

Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,464,490.00 (найман сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэг (Ж.Одгэрэл)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 8 нэр төрлийн 5,304,490.00 (таван сая гурван зуун дөрвөн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 3,160,000.00 (зурван сая нэг зуун жаран мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэг (Ж.Одгэрэл)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Эмчийн харилцааны газрын
224 оны 12 дугаар сарын 31-ний
н А/125 дугаар тушаалын хавсралт

ДАНСНААС ХАСАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: Налайх дүүргийн 140-р цэцэрлэг

	Эд хөрөнгийн нэр	Ашигласан гижил	Хэмжээний Хэмжээ	T00 хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүнгэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-мэргэжилтэний дүнгэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
Тоног төхөөрөмж													
1	Принтер /5520 sharp/	14	ш	1	1,299,990.00	1,299,990.00	1,299,990.00	-	Ашиглаа бодомжгүй	Устгах	Устгах	Устгах	Устгах
2	Принтер /epson k200/	6	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00	-		Устгах	Устгах	Устгах	Устгах
3	Принтер /HP-1018/	10	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00	-		Устгах	Устгах	Устгах	Устгах
4	Зөөврийн компьютер /Dell/	5	ш	1	1,749,500.00	1,749,500.00	1,749,500.00	-		Устгах	Устгах	Устгах	Устгах
5	Телевизор НКС 32 инч	6	ш	1	650,000.00	650,000.00	650,000.00	-		Устгах	Устгах	Устгах	Устгах
6	Цахилгаан пийшин	14	ш	1	1,650,000.00	1,650,000.00	1,650,000.00	-		Устгах	Устгах	Устгах	татах
7	Шарах шүүгээ	14	ш	1	1,160,000.00	1,160,000.00	1,160,000.00	-		Устгах	Устгах	Устгах	татах
Тоног төхөөрөмжийн нийт дүн					7	7,209,490.00	7,209,490.00						
Тавилга, эд хогшил													
1	Сургалтын ширээ	14	ш	2	72,000.00	144,000.00	144,000.00	-	эвдэрсэн	актлах	Устгах	Устгах	Устгах
2	Хундуулагчий сейф	14	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00	-	эвдэрсэн	актлах	Устгах	татах	татах
3	Хувцасны модон өлгүүр	14	ш	2	100,500.00	201,000.00	201,000.00	-	эвдэрсэн	актлах	Устгах	Устгах	Устгах
4	Модем	14	ш	2	280,000.00	560,000.00	560,000.00	-	эвдэрсэн	актлах	Устгах	Устгах	Устгах
Тавилга, эд хогшлийн дүн					7	802,500.00	1,255,000.00	1,255,000.00	-		-		
					Нийт дүн								
					Үүнээс : Худалдах хөрөнгө								
					Акталж устгах хөрөнгө								
					Татан төвлөрүүлэх хөрөнгө								
					Худалдсанаас олох орлого								
					НӨХГ-т төвлөрүүлэх /30%/								